

БАРИЛГЫН ӨРГҮҮРТ ХИЙХ МАГАДЛАЛ.

Барилгад дараах 3 төрлийн өргүүр ашиглагдана:

1. Ачаа зөөврийн тавцант өргүүр
2. Хүн, ачаа зөөврийн барилгын лифт
3. Хүн дээр нь гарч барилгын заслын ажил гүйцэтгэх зориулалттай дүүжин өргүүр

Барилгын өргүүрт бүрэн ээлжит болон ээлжит бус магадлал хийнэ. Бүрэн магадлалыг өргүүрийг анх ашиглаж эхлэхийн өмнө хийлгэж, үүний үр дүнд үндэслэн өргүүрийг ашиглах зөвшөөрөл өгөгдөнө.

Өргүүрийн техникийн бүрэн магадлалыг дараах тохиолдолд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- а) ачаа-хүн зөөврийн өргүүрийг шинэ байрлалд угсарсны дараа;
- б) өргүүрт шинэчлэлт, өөрчлөлт хийсний дараа.

Ээлжит магадлалыг жил бүр, шилжүүлэн байрлуулснаас үл хамааран хийнэ. Өргүүрийн бүрэн, ээлжит магадлалаар хийгдэх ажил нь адил байна.

Ээлжит бус техникийн магадлалыг ган татлагыг солих, өргөх механизмыг засварлах, (солих), баригч, хурд хязгаарлагчийг солих, ослоос хамгаалах хэрэгсэл, удирдлага, цахилгааны бүдүүвчид өөрчлөлт оруулсны дараа гүйцэтгэнэ. Ээлжит бус техникийн магадлал нь засварлагдсан эсвэл солигдсон зангилааны ажиллах чадварыг шалгах боломжтойгоор хийгдэнэ.

Техникийн магадлалаар дараах ажил хийгдэнэ.

- a. Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрмийн дагуу өргөх төхөөрөмжийг ашиглах орон тоо зохион байгуулалтыг хийж, мэргэжлийн эрх бүхий хүмүүсийг томилсон эсэх
- b. Техникийн болон ашиглалтын бичиг баримтын бүрдэл бүрэн эсэх;
- c. Угсаргааг зургийн дагуу хийсэн болон өргүүрийн техникийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг үзэж, хэмжиж, шалгах;
- d. Статик, динамик туршилт хийх;

Өргүүрийг ашиглах орон тоо зохион байгуулалтыг хийснийг шалгах.

Үүнийг шалгахын тулд эзэмшигч байгууллагын дарга эсвэл өргүүрийн бүрэн бүтэн байдал хариуцагчтай уулзаж дараах зүйлсийг үзнэ:

- Өргүүрийн бүрэн бүтэн байдлыг хариуцагчийг томилсон тушаалыг шалгана.
- Мэргэжлийн операторчинг ажиллуулдаг эсэхийг мөн түүнд мэргэжлийн үнэмлэх байгаа эсэх, операторч жил бүр аттестатчилалд хамрагдсан байдлыг тус тус үзэж шалгана.
- Өргүүрийг ашиглах үед ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагааг хариуцагчийг тушаалаар томилон ажиллуулж байгааг
- Өргүүрийн ашиглалтын аюулгүй байдлын хяналт хариуцагчийг томилон, ажиллуулж байгааг.

Техникийн болон ашиглалтын бичиг баримтын бүрдэл бүрэн эсэхийг шалгах.

Өргүүрийг ашиглалтад хүлээн авахад байх ёстой бүх заавар, бичиг баримтыг эзэмшигч, ашиглагчид хадгалагдаж, өргүүрийн эзэмшил өөр байгууллага, хүнд шилжих нөхцөлд бүрэн бүтнээр нь хүлээлцэж байх үүрэгтэй байдаг

Өргүүрийг хүлээн авахад дараах бичиг баримт байх шаардлагатай:

- Өргүүрийг угсрах, ашиглах, түүнд засвар, техникийн үйлчилгээ хийх заавар
- Цахилгааны схем, заавар
- Өргүүрийн паспорт

- Өргүүрт бүрэн магадлал хийсэн акт

Ашиглалтын явцад өргүүрийн паспорт хөтлөгдөн, хийсэн магадлалын актууд нэмэгдэн хавсрагдаж байх болно. Техникийн паспортын хөтлөлтөд дараах бичилтүүд хийгдсэн байхыг шалгана:

- Өргүүрийн бүрэн бүтэн байдал хариуцагчийн нэрийг түүний томилсон тушаалын он сар өдөр, дугаарын хамт бичиж гарын үсгийг нь зуруулсан байна.

- Өргүүрийн засвар, техникийн үйлчилгээ хийх мэргэжилтэн буюу мэргэжлийн байгууллагын нэр, тэдгээрийг томилсон тушаалын болон байгуулсан гэрээний он, дугаарыг бичээд гарын үсгийг нь зуруулж, байгууллагын тамгыг нь даруулсан байна.

Эдгээр хариуцагч этгээдүүд солигдсон нөхцөлд шинээр томилогдсон этгээдийн тухай тэмдэглэлийг дээрхийн адил үргэлжлүүлэн бичиж явна

- Өргүүрт засвар, техникийн үйлчилгээ хийсэн этгээд түүнд гүйцэтгэсэн ажил, өргүүрийн техникийн байдал, цаашид авах арга хэмжээ, нөөцлөх сэлбэгийн талаар мөн ашиглагч байгууллагын зүгээс анхаарвал зохих зүйлсийн талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж явна. Үүнийг өргүүрт засвар хийсэн этгээд бичих, түүний бүрэн бүтэн байдал хариуцагч бичүүлэх үүрэгтэй байдаг

- Өргүүрт хийсэн аливаа магадлал, туршилтийн тухай бичиж магадлалын актыг хавсарган гүйцэтгэсэн хүний гарын үсгийг зуруулсан байна.

Техникийн паспортыг хөтөлснөөр энд өргүүрийн техникийн байдлын түүх бичигдэж, энэ нь аливаа эвдрэл, осол гарсан нөхцөлд түүний шалгааныг тогтоох, нотлох баримт болох ба ашиглалтад гарсан зардлыг тооцох, дараа жилийн зардлын төлөвлөлт хийхэд лавлах материал болж өгдөг

Өргүүрийн техникийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг шалгах;


Өргүүрийн техникийн бүрэн магадлалын үед дараах зангилаа, эд ангид үзлэг, шалгалтыг гүйцэтгэнэ. Үүнд:

- а) өргөх механизм, түүний цахилгаан хөдөлгүүр, редуктор, хүрд, тоормос, муфт;
- б) цахилгаан удирдлагын систем;
- в) ослоос хамгаалах хэрэгсэл нь бүрэн бүтэн ажиллагаатай эсэх;
- г) төмөр хийц, тэдгээрийн гагнууран холбоос, тавцан, хашлага;
- д) чиглэл өөрчлөх дамарнууд;
- е) ган татлага, түүний бэхэлгээний байдал;
- ж) “Цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм”-ийн дагуу дамжуулах утасны тусгаарлагч ба газардуулгын байдал, тэдгээрийн эсэргүүцлийг хэмжсэн дүнгийн талаар тэмдэглэл;
- з) гэрэлтүүлэг, дохиолол.
- и) өргүүрийг барилгад бэхэлсэн бэхэлгээний найдвартай байдал.

Дүүжин өргүүрийн техникийн байдлыг шалгахад анхаарах зүйлс:

1. Барилгын дээвэр дээр гараад түүний дүүжлэх консольд дараах үзлэг хийнэ:

- Дүүжин өргүүрийн ажлын болон ослын ган татлагууд, дам нурууны бөхөлгөөний уян татуурганы бэхэлгээнүүд суларсан эсэхийг доорх зурагт үзүүлсний дагуу, 3 дахь бэхэлгээний дараах тунарсан хэсэг байгааг шалгана. Энэ тунарсан хэсэг байгаа нь ган татлага найдвартай бэхэлгээтэй байгааг илтгэнэ



- Эсрэг ачаа бүрэн хэмжээгээрээ тавигдсан, шөрөгт углагдан орсонн байгааг шалгана
- Эсрэг ачааны суурь дам нуруунд бэхлэгдсэн болт нь мултрахааргүй найдвартай байгааг шалгана. /Зурагт сумаар заав/



- Консолийн үзүүрт бэхлэгдсэн, ажлын болон ослын ган татлага нь нэг сэнжинд биш тус тусдаа нэг нэг сэнжинээс дүүжлэгдсэн эсэхийг шалгах
 - Өндрийг хязгаарлах тавагны бэхэлгээ найдвартай эсэхийг шалгах
 - Дамнуурганы урд хөлнөөс хойших хэсгийн урт нь угсаргааны зурагт заасан хэмжээнд хэвийн байгаа эсэхийг шалгана
2. Доош бугаад хүн суух дүүжин тавцан дээр очоод 2м хүртэл өндөрт өргөж буулгах маягаар дараах зүйлсийг шалгана:
- Ажлын болон ослын ган татлаганы доод төгсгөлд зориулалтын нь ачааг дүүжилсэн, ачаа нь газраас хөндий байгаа эсэхийг шалгана
 - Дүүжин тавцанг хоёр хөтлүүрээр нь мөн нэг нэгээр нь ээлжлэн ажиллуулж хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана
 - Дүүжин тавцанг өргөж үзэхдээ өндрийг хязгаарлах хоёр талын таслагчийг дарж, найдвартай зогсоож байгааг үзнэ.
 - Хоёр талын хөтлүүрийн тоормосыг гараар тавиулж, бариулж ажиллагаа найдвартай байгаа эсэхийг шалгана.
 - Дүүжин тавцангийн нэг талыг нь буулган баригч ажиллаж байгааг шалгана. Дүүжин тавцан 15°-аас илүү хазайхад баригч автоматаар барих ёстой. Ийм маягаар нөгөө тийш нь хазайлган шалгана.
 - Ган татлагыг дүрэмд заасан, гологдол болгох нормын дагуу магадлана.

Ачааны тавцанд өргүүрийн техникийн байдлыг шалгахад анхаарах зүйлс:

1. Хөтлүүрийг дараах байдлаар шалгана:
 - Цахилгаан хөдөлгүүр, редуктор, хүрд, тоормосны бэхэлгээний болтууд найдвартай байх.
 - Тоормосны эд ангийг холбосон болтууд бүрэн чангалагдсан, накладка норм хэмжээнээс хэтэрч элэгдээгүй, тоормос тавигдсан үед накладка тоормосны булнаас жигд хөндийрдөг, аль нэг нь булд хавирдаггүй байх
 - Редуктороос тос гоожоогүй, тосны түвшинг нь шуп-ээр нь шалгахад хэвийн хэмжээнд байна.
 - Ган татлага хүрдэнд жигд эрэмблэгдэн ороогдож байгааг үзэх.
2. Чиглэл өөрчлөх ган татлага, дамруудыг дараах байдлаар шалгана:
 - Ган татлагыг дүрэмд заасан, гологдол болгох нормын дагуу магадлана

- Ган татлаганы төгсгөлийн бэхэлгээг дээр үзүүлсэн, дүүжин өргүүрийн ган татлаганы бэхэлгээний адил хийгдсэн эсэх, түүний захын бэхэлгээний өмнөх тунараа нь байгаа эсэхийг шалгана.
 - Дамрууд тэнхлэг дээрээ ганхаагүй суурилсан байна
 - Дамрууд зөв байрлаж, ган татлага дамар луу жишүү ороогүй байх
3. Даацын төмөр хийцийг дараах маягаар шалгана:
- Даацын төмөр хийцийг зааврын дагуу бүрэн найдвартай угсарсан эсэхийг магадлана.
 - Даацын төмөр хийцэд тахийж мурийсан хэсэг байгаа эсэх, гагнуурт ан цав үүссэн эсэхийг шалгана
 - Дээд хөндлөн холбоос хэсгийн бэхэлгээ найдвартай эсэх, түүнд доош унахаас хамгаалсан тээглүүр байгаа эсэхийг шалгана
 - Ган татлага бэхэлсэн сэнж найдвартай байгаа эсэхийг шалгана
 - Ашиглалтын зааварт тусгагдсаны дагуу өргүүр барилгатай найдвартай, бүрэн бэхлэгдсэн эсэхийг шалгах
4. Ачаа өргөх тавцанг дараах байдлаар шалгана:
- Тавцан түүний хашлага, хаалга найдвартай хэвийн байгаа эсэхийг шалгана
 - Тавцангийн унахаас хамгаалсан автомат тээглүүр /ослоос хамгаалах хэрэгсэл/ ажиллагаатай эсэх, түүний татах пүрш бүрэн, уяраагүй эсэхийг шалгана
 - Тавцангаас ачаа буулгаж байх үед түүнийг унахаас хамгаалах гар удирдлагатай тээглүүр хэвийн байгаа эсэхийг шалгана
 - Тавцангийн шилжилтийг чиглүүлэх 8 өнхрөгч ролик тэнхлэг дээрээ найдвартай бэхлэгдсэн, босоо чиглүүлэгчтэй харьцах зай хэмжээ нь өргүүрийн нийт өндрийн турш жигд байгаа эсэхийг магадлах

Хүн, ачаа зөөврийн барилгын лифтний техникийн байдлыг шалгахад анхаарах зүйлс:

1. Барилгын лифтийг угсралтын зааврын дагуу бүрэн, зөв, найдвартай угсарсан, эд ангийн болтууд нь найдвартай чангалагдсан эсэхийг шалгах
2. Барилгын лифтийг барилгад угсралтын зааврын дагуу бүрэн, зөв, найдвартай бэхэлсэн эсэхийг шалгах
3. Лифтний чиглүүлэгчид хугарсан, тахийж мурийсан хэсэг байгаа эсэхийг үзэж магадлана.
4. Ослоос хамгаалах хэрэгслийг дараах маягаар шалгана:
 - Доод хашлаганы хаалганы таслагчийг лифтийг явж байх үед хаалгыг онгойлгон лифт зогсож байгааг шалгана
 - Лифтийн бүхээгний хоёр хаалганы таслагчийг лифтийг явж байх үед хаалгыг онгойлгон лифт зогсож байгааг шалгана
 - Бүхээгний нээлхийн таслагчийг лифтийг явж байх үед нээлхийг онгойлгон лифт зогсож байгааг шалгана
 - Лифтийн дээд доод хязгаарын болон давхар хамгаалалтын таслагчийг лифтийг явж байх үед таслагч дээр нь дарж лифт зогсож байгааг шалгана. Эсвэл таслагч дээр нь дараад бүхээгийг явуулах команд өгөхөд бүхээг хөдлөхгүй байгааг үзэж магадлана.
 - Бүхээгний баригчийг шалгахдаа бүхээгийг 3м өндөрт өргөөд хөдөлгүүрүүдийн тоормосыг салгах, тусгай гар удирдлагыг шитэнд холбоод, түүний товчлуур дээр дарна. Энэ үед бүхээг доош хурдтай унах ба энэ үед баригч ажиллаж байгааг магадлан шалгана. Баригчийг шалгаж, турших үед оператор бүхээгт байхыг хориглоно.
5. Лифтийн цахилгааны холболт, газардуулга хэвийн байгаа эсэхийг үзэж шалгана.

Статик туршилт хийх.

Статик туршилтыг гүйцэтгэхдээ өргүүрийн даацыг дараах байдлаар ихэсгэж авна. Үүнд:

- ачаа, хүн зөөврийн болон дүүжинт өргүүрийн хувьд 100%,
- ачааны өргүүрийн хувьд (цухуйж гараагүй ачаа өргөх тоноглолтой үед) 50%,
- цухуйж гарсан ачаа өргөх тоноглолтой үед 25%.

Статик туршилтын үед ачаа ачсан өргөх тоноглолыг ачих талбайн хамгийн доод түвшингээс 150 мм-ээс илүүгүй өндөрт хөдөлгөөнгүй байдалд 10 минутын хугацаанд байлгах ба энэ үед ачааг алдахгүй, мөн түүнчлэн барилгын дээвэр дээр гаран, дүүжлэх дам нурууны төмөр хийцэд хэв гажилт, ан цав ба бусад гэмтэл согог илэрсэн эсэхийг шалган, бүх зүйл хэвийн байвал статик туршилтыг даасанд тооцно.

Динамик туршилт хийх

Өргүүрийн динамик туршилтыг даацаас 10%-ийн илүү ачаатайгаар бүх үйлдлийг 3-аас доошгүй удаа гүйцэтгэнэ. Энэ үед тавцанг завсрын зогсоолд зогсоож үзэх ба өргөх механизмын үйл ажиллагаа, тоормосны ажиллах чадварыг шалгана.

Баригчийн (ослын зогсоогуур) туршилтыг даацаас 10%-ийн илүү ачаалалтайгаар ашиглалтын баримт бичигт заасан аргачлалын дагуу явуулна. Үүнд:

- хурд хязгаарлагчаар тоноглогдсон өргүүрийг бол ажиллуулж,
- хурд хязгаарлагчаар тоноглогдоогүй өргүүрийн хувьд, ган татлагыг тасарсан байдлыг орлуулан гүйцэтгэж,
- хэдрэг араат өргүүрийн хувьд, тоормосыг салгах товчлуурыг дарж, өргүүрийн доошлох хурдыг ихэсгэж

Магадлал хийсэн инженер техникийн ажилтан нь техникийн бүрэн магадлалын үр дүн, дараагийн магадлал хийх хугацааны хамт паспортад бичнэ.

Паспортын бичилт нь өргүүр бүрэн бүтэн бөгөөд энэхүү дүрмийн шаардлагын дагуу угсрагдаж, техникийн бүрэн магадлал хийгдсэнийг нотолж байвал цаашид ашиглахыг зөвшөөрнө.